

Манмин Мэдээ

Номер 25 2012 оны Наймдугаар сарын 5

2012 оны магтаалын Фестивал дээр “Есүс Христ”-г магтан дуулсан нь Ариун Сүнсний хүч нөлөөгөөр Израйльд сэргэлтийн гал дүрэлзэн аслаа.



■ Зураг 1: Доктор И Жей руг пасторыг урьсан “2009 оны Израйлийн нэгдсэн их цуглаан”-ы дараа Израйлын номлогч нар Ариун Сүнсний хүчийг аван Есүс Христийг зоригтой тунхагладаг болов. ■ Зураг 2: Тавдугаар сарын 19-нд болсон “2012 оны Магтаалын Фестивал” ■ Зураг 3: “2012 оны Магтаалын Фестивал”-д оролцсон Манмин Төв сүмийн “Эрч хүч” багийн урлагын тоглолт ■ Зураг 4: “2012 оны Магтаалын Фестивал”-н дараах дурсгалын зураг ■ Фото 5: Дэлхийн олон газруудаар явж эрх мэдэлт хүчит гар алчуур залбирал хийж буй “Кристалл Форум”-н дарга Даниел Розен пастор ■ Зураг 6: 2011 оны Арванхоёрдугаар сард болсон “Кристалл Форум”-н 3 жилийн ойн баяр ■ Фото 7: 2011 оны Аравдугаар сар “Израйлийн нэгдсэн их цуглаан” болсны 2жилийн ойн үйл ажиллагаа

Кристалл форум (Израйлын номлогчдын нэгдсэн холбоо)-с зохион байгуулсан 2012 оны “Магтаалын Фестивал” тавдугаар сарын 19-нд Латрун Мини Израйльд амжилттай болж өнгөрөв. Тус үйл ажиллагаа нь нийт 2,000 хүмүүс оролцсон бөгөөд Орос, АНУ, Украин, Болгар, Финландаас нэртэй хүндтэй олон магтаалын удирдагч нар багууд оролцож, ТВН-Россия телевизээр дамжуулан фестивалийн үйл ажиллагааг 150-д орнуудад шууд цацав.

Манмин Төв сүмийн магтаал дуу бүжгийн багийн харьяа “Эрч хүч” баг болон Сун Ёон лаг сүм үйлчлэгч нар урилгаар энэ фестивалд оролцсон ба магтаал дуу болон бүжгээр Бурхандаа алдрыг өргөв. Урилгаар оролцсон манай хүмүүс тэнгэрийн орныг дүрслэх мэт үзэсгэлэнтэй хувцас, хэрэгсэлтэйгээр бүжгээ сонирхуулж, Еврей, Орос, Лингала хэмээх 3 хэлээр Ариун Сүнсээр бялхам, сэтгэл хөдлөм тоглолтуудыг үзүүлэхэд оролцогчид “Тэнгэрийн орныг харах шиг боллоо”, “Гадаад хэл дээрх магтаал дууны аялга нь маш цэвэр, тод байлаа. Арай понограмм тавьсан юм биш биз” гэх

зэргээр ихэд гайхаж, мөн маш их сэтгэл хангалуун байсан юм.

Энэ удаагийн арга хэмжээ нь Израйлийн сүмүүд нэгдэн зоригтойгоор Есүс Христийг магтан дуулж байгаагаараа онцлог бөгөөд гүн утга учиртай үйл явдал байлаа. Есүс Христийг хүлээн авсан гэдэг утгаараа олон нийтэд болон нийгэмд гадуурхагдаж байсан Мессаник Иудейчүүд нь Ариун сүнсний нөлөөгөөр хүчийг олж Сабан Итэн гэх гадаа талбайд Есүс Христийг магтан дуулдаг хүмүүс болон өөрчлөгдсөн юм.

Доктор И Жей руг тэргүүн пастор 2007 оноос 2009 оны хооронд нийт гурван жилийн хугацаанд тэрээр Израйльд 12 удаа айлчлахдаа Израйлийн бүх газруудаар тойрон явж, эрх мэдэлт хүчний үйлсээр сайн мэдээг тараасан юм. Энэ хүч нөлөөгөөр дамжуулан тухайн орны пастор номлогч нар Израйль руу хандсан Бурханы хайр ба хүсэл төлөвлөгөөг ухаарч, Израйлийн сүмүүдийн өсөлт ба пасторуудын нэгдмэл байдлын төлөө гал халуунаар өөр хоорондоо нэгдэж “Кристалл Форум”-ийг бий болгосон юм.

Үүний дараа, “Кристалл Форум” нь

Иерусалимын ИСС буюу (Олон Улсын Конференцийн Төв)-д “Доктор И Жей руг пасторыг урьсан 2009 оны Израйлийн нэгдсэн их цуглаан”-ны үйл зохион байгуулахад нь хүлээн авч тусалж дэмжсэн юм. Энэ нэгдсэн их цуглаанаар Доктор И Жей руг пастор “Зөвхөн Есүс яагаад бидний Аврагч вэ?” хэмээх сэдэвт сургаалыг айлдаж, сайн мэдээний сэргэлтийг авчран, уг цуглааны үйл ажиллагааг дэлхийн 220-аад оронд шууд цацан нэвтрүүлсэн юм.

“Кристалл Форум”-н пастор номлогч нар нь Доктор И Жей руг тэргүүн пасторын залбирал хийж өгсөн гар алчуураар (Үйлс 19:11-12) Израйль дотроо мөн хилийн чанадад АНУ, Орос, Украин, Болгар, Естони болон Финландад эдгэрлийг цуглаануудыг удирдан явуулсаар байгаа билээ. Энэ цуглааны үйл ажиллагаа болж буй газар болгон Ариун сүнсний гал мэт хүч нөлөөгөөр гэмшицгээж, өвчнүүд эдгэрч, амьдрал өөрчлөгдөн шинэчлэгдсэн гэх маш олон гэрчлэлүүдээр дүүрэн бүртгэгдсэн байна.

Мөн түүнчлэн Доктор И Жей руг пасторын номууд “Сэрэгтүн Израйль!”

“Загалмайн Үг”, “Итгэлийн Хэмжээ”, “Үхлийн өмнө Мөнхийн Амьдралыг Амссан нь”, “Тэнгэрийн орон I ба II” хэмээх номууд Израйльд хүчтэй түгээгдсээр байна. Мөн ариун сайн мэдээг нарийн тодорхой заадаг Манмин олон улсын библейн сургууль нь Тел Авив, Ашдод болон Иерусалимд тус тус салбараа нээж (MIS) нь Украин, Кипр болон Казакстанд хүртэл хүрээгээ тэлэв.

Одоогын байдлаар, Израйльд ТВН-Россия, CNL, Холи гад ТВ, Родной ТВ-үүдээр дамжуулан өдөр бүр Доктор И Жей руг пасторын сургаалиуд болон өвчтөнүүдийн төлөөх эдгэрлийн залбирал цацагддаг учраас олон хүмүүс ивээл авч байна. Мира Рэбхари итгэгч нь ТВН-Россия телевизээр дамжуулан Доктор И Жей руг пасторын цаг, орон зайн үл хамаарах хүчит залбиралыг аваад түүний эрүүл болж, архи, хар тамхинд болон орсон хүү нь өөрчлөгдсөн тухай гэрчиллээ бидэнтэй хуваалцсан юм.

Цаашдаа Израйльд ариун сайн мэдээ тараах үйл ажиллагаа улам өргөжин тэлж, Ариун Сүнсний гал мэт хүч нөлөө улам их бий болно гэдэгт найдаж байна.

«Загалмайн Үг» цувралаас -(23)

Мөнх амь (1)

Итгэдэг гэсэн мөртлөө Аврал хүртэж чадахгүй байх тохиолдол (2)

“Намайг ‘Эзэн минь, Эзэн минь’ гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно” (Матай 7:21).

“Хэрэв хэн нэг нь үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэж байгаа ах дүүгээ харвал, залбиран гуй. Тэгвэл үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэгсдэд амийг Тэр өгнө. Үхэлд хүргэх нүгэл гэж бий. Үүний төлөө залбир гэж би хэлэхгүй. Зөвт бус байдал нь бүгдээрээ нүгэл мөн. Үхэлд хүргэхгүй нүгэл гэж бий” (1 Иохан 5:16-17).

Есүс Христийг хүлээн авч Бурханд итгэдэг хүмүүсийн туйлын зорилго нь жинхэнэ аврал ба тэнгэрийн орон юм. Хэрэв Бурханд итгэдэг гэсэн мөртлөө аврал хүртэж чадахгүй там руу орвол ямар өрөвдөлтэй нэгэн билээ. Харин Бурханы хүслийн дагуу үйлддэг хүн болвол аврал хүртээд зогсохгүй дахин ирэх Эзэнтэй агаар мандалд уулзан хурим найранд оролцох болно.

Энэ үед сайн мэдээг сонсоогүй хүмүүс энэ газар дээр үлдэж гашуудан, сандралдаж гай зовлонд унах болдог. Эзэнд итгэдэг сүмд явдаг ч гэсэн дээшээ аваачигдахгүй үлдвэл ямар их харамсалтай бөгөөд гашуудмаар явдал вэ?

Мэдээжийн аврал авна гэж бодож байтал тийм биш байгаа бодит байдлаа харвал үнэхээр аймшигтай бас харамсмаар явдал юм. Тиймээс Эзэнд итгэдэг гэсэн мөртлөө аврал авч чадахгүй байх тохиолдолын талаар тодорхой мэдэж, эцэст нь үхэл рүү явах явдал байхгүй байхыг хүсье.

1. Бурханы эрх мэдэлт хүчийг үйлддэг, Бурханы таалагч боолыг эсэргүүцэх Ариун Сүнснийг доромжлох, саад хийх, эсэргүүцэх

“Ариун Сүнснийг доромжлох, саад хийх, эсэргүүцэх” гэдэг нь Ариун Сүнсний үйлсийг сөргөсөн үг яриа болон үйлдлээр Бурханы үйл ажиллагаанд саад хийх тэрсэлдэх гэсэн үг юм. Энэ нь Бурханыг мэдэхгүй дэлхийн хүмүүс сүм цуглааныг хавчин гадуурхахаас өөр зүйл бөгөөд “Итгэлтэй” гэгдэх үнэнийг мэддэг мөртлөө өөрийн атгаг байдлын улмаас Бурханы хүч нөлөөг эсэргүүцэн тэрсэлддэг зүйл учраас аврал хүртэх боломжгүй билээ.

Бурханы эрх мэдэлт хүчээр өвчин болон сул доройг эмчилж, муу ёрын сүнснүүдийг зайлуулах зэрэг хүч нөлөөг хараад харин ч эсрэгээр “сатаны хүч” гэж Ариун Сүнснийг доромжлон, саад хийж, эсэргүүцэж байгаа хүнийг яаж Бурханы хүч гэж хэлж чадах билээ? Үнэхээр Бурханд итгэдэг итгэдэг сайхан сэтгэлтэй хүн бол хүний хүч чадлаар бүтээж чадахгүй агуу гайхамшигт Бурханы хүчийг хараад Бурхандаа талархал ба алдрыг өргөдөг билээ. Гэвч атгаг хүмүүсүүд нь харин ч эсрэгээр Ариун Сүнсний хүч нөлөөг үгүйсгэж, Бурханыг эсэргүүцэж байгааг харж болох юм.

Атгаг сүнснүүд хүний өвчний эдгээж өгөх юм уу, сул дорой хэсгийг хэвийн болгож өгөх хүч ч байхгүй төдийгүй магадгүй тэдэнд тийм хүч байлаа ч атгаг сүнснүүд шүглэсэн чөтгөрийг хөөж, өвчнийг эдгээж Бурханд алдрыг өргөх боломжгүй юм.

Мөн түүнчлэн Бурханы баталж өгсөн эрх мэдэлт хүчийг үйлддэг Бурханы боолын тухай түүнийг эсэргүүцэх ч мөн адил билээ. Энэ нь Бурханы баталсан хүнийг үгүйсгэвэл түүгээр дамжуулан гарч буй Ариун Сүнсний



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

хүч нөлөөг ч мөн доромжилж буй хэрэг бөгөөд эцэстээ энэ нь Бурхантай тэрсэлдэх явдал билээ. Египетээс гарсан Израйлийн ард түмэн хоол ундгүй болох үедээ Мосе болон Ааронд гомдоллоход Мосе тэдэнд, “ЭЗЭН орой нь та нарт идэх мах өгч, өглөө нь та нарт цадтал талх өгнө. Учир нь Өөрийнх нь эсрэг гаргасан та нарын гомдлыг ЭЗЭН сонсдог. Бид юу юм бэ? Та нарын гомдол бол бидний эсрэг биш, харин ЭЗЭНий эсрэг юм гэв” (Египетээс гарсан нь 16:8) гэсэн байдаг билээ.

Библийн Шинэ гэрээний Үйлс номон дээр үзвэл Ананиа болон Саппира гэх гэр бүлийн 2 өөрсдийн газраа заран Бурхандаа өргөл өргөхөөр шийддэг ч шуналаасаа болж газрын үнийн зарим хэсгийг нууж, элч Петрт өгөхдөө бүгдийн өргөж буй мэт болсон билээ. Энэ нь Петр-г хуурч байгаа бус Ариун сүнснийг хуурч байгаа хэрэг бөгөөд Бурханд худал хэлсэн учир гэмших ч боломж ололгүй шууд үхдэгийг харж болох юм. (Үйлс 5:1-5)

2. Үхэлд хүргэх гэм нүглүүд: Бурханы Хүүг дахин загалмайд цовдолж илэрхий гутамшиг болгох

Библийн Шинэ гэрээний Еврей 6:4-6-д, “Учир нь нэгэнтээ гэгээрүүлэгдсэн бөгөөд тэнгэрлэг бэлгийг амссан, Ариун Сүнсний хуваалцагч болсон, Бурханы сайн үгийг болон ирэх үеийн хүчүүдийг амссан атлаа, дараа нь завхайрсан хүмүүс дахин шинэчлэгдэн, гэмших боломжгүй. Учир нь тэд өөрсдөдөө Бурханы Хүүг дахиад цовдолж, илэрхий гутамшиг болгодог ажээ” хэмээн айлдсан байдаг юм.

Энэ нь Ариун Сүнснийг аваад ивээл хүртсэн хүн, тэнгэрийн орон ба там байдаг гэдгийг мэддэг бөгөөд үнэний үг сургаалийг сонсоод итгэдэг мөртлөө дэлхийн уруу татлагад орон Бурханаасаа холдон завхарснаар Бурханы алдрыг илэрхий гутаах тохиолдол юм. Хэдийгээр сайн мэдээг сонсоод сүмд явдаг байсан хүн ч гэсэн мэдлэг төдий итгэлтэй байж байгаад дэлхий рүү татагдан унасан бол хэзээ нэгэн цагт дахин аврал хүртэх ивээлийг авах боломжтой юм. Гэтэл

Ариун сүнсний хүч нөлөөн дотор ивээл хүртэж, дахин дэлхий рүү эргэсэн хүмүүс нь харанхуйгаар дүүрч, илүү ихээр сатаны нөлөөнд автдаг билээ. Угаасаа Бурханд итгэдэггүй хүнээс ч илүү атгагаар өмнө авч байсан ивээлийг үгүйсгэж, мөн сүмийн итгэгчдийн хавчих тохиолдол ч бий.

Ингэж Эзэний загалмайг илэрхий гутамшиг болгодог хүмүүс нь гэмшлийн сүнс авах боломжгүй учраас эцэстээ үхдэгийг харж болно. Есүсийн шавь байсан Искариотын Иудасыг авч үзэхэд л ойлгомжтой юм. Тэрээр өөрийн биеэр Есүсийн хийж буй хүчит үйлсүүдийг харж байсан ч шуналаасаа болж Есүсээс урван Түүнийг 30 мөнгөн зоосоор худалдан баривчлуулсан байдаг. Тэгээд Есүсийг баривчлагдсаны дараа мөс чанарын маш хэцүү байдлыг мэдэрч, гэмших гэсэн боловч эцэстээ гэмшлийн сүнс өгөгдөөгүй нь улмаас зүрх сэтгэлийн өвчнөө тэсэж чадалгүй амиа хорлодог билээ.

3. Үхэлд хүргэх гэм нүглүүд: “Үнэнийг мэддэг боловч санаатайгаар үйлдэх гэм нүгэл”

Еврей 10:26-27-д, “Хэрэв бид үнэний мэдлэгийг хүлээн авсны дараа санаатайгаар нүгэл үйлдвэл нүглийн төлөөх тахил цаашид үлдэхгүй. Харин шүүлт хийгээд эсэргүүцэгчдийг шатаах галын хилэнг айн чичирч хүлээх нь үлдэнэ” хэмээн айлдсан байдаг. Энэ нь үнэнийг мэддэг итгэлтэй гэсэн мөртлөө Бурханы хориглосон ёс бус зүйлийг санаатайгаар хийдэг хүмүүсийг хэлж байгаа юм.

2 Петр 2:21-22-д, “Учир нь зөвт байдлын замыг мэдээд, өөрсдөд нь өгөгдсөн ариун тушаалуудаас нүүр буруулан эргэснээс энэ замыг мэдээгүй байсан нь тэдэнд дээр байх байсан. Тэдний хувьд ‘Нохой бөөлжсөө долоодог, гахайг угаасны дараа шаварт буцаж хөлбөрдөг’ хэмээх үнэн сургаалт үгийн дагуу тохиолдсон аж” хэмээн айлдсан байдагчлан зориуд санаатайгаар үйлдчихээд буруу зүйл хийснээ мэдээд гэмшсэн ч дахин гэм нүгэл үргэлжлүүлэн давтан үйлддэг хүмүүсийг хэлж байгаа юм.

Израйлийн Давид хаан түр зуур сорилтонд унаж хүн алах хэмээх том гэм үйлдсэн явдал болсон юм. Гэтэл Давид руу Бурханы эш үзүүлэгч ирэн түүнийг нь зэмлэхэд тэрээр шууд гэмээ гэмшин эргэдэг билээ. Түүний улмаас том хэмжээний сорилтыг туулах болж, соригдож байхдаа ч даруухнаар давсан тул зүрх сэтгэл дэх гэмт чанарыг ч хүртэл хаяж Бурханы өмнө төгс хүн болон өөрчлөгдсөн юм.

Эсрэгээр нь Саул хаанд Самуел эш үзүүлэгч хүрч ирээд ухааруулж өгсөн ч “Ард түмний төлөө л ингэж хийлээ” гэж шалтаглаж байсан юм. Зүрх сэтгэлийнхээ гүнээс гэмших сэтгэлгүй байсан тул Бурханы өмнө дахин дахин гэм нүгэл үйлдэн эцэст нь нүглийн хана босож Бурханаас хаягдсан билээ.

Өнөө үед ч мөн адил билээ. Итгэлтэй бөгөөд үнэнийг мэддэг хүмүүс гэм нүгэл үйлдвэл Ариун Сүнс гашуудан ухааруулж өгдөг тул чин сэтгэлээсээ гэмшин, гэрэл дотор үйлдэн сайны үр жимсийг гаргах хэрэгтэй юм. Харин санаатайгаар гэм нүгэл үйлдвэл Бурхан түүнээс нүүрээ бууруулах ба тэр хүнд гэмшлийн сүнс бууж ирэхгүй бөгөөд эцэст нь ариун сүнс нь бөхдөг болох нь үнэн билээ (Тессалоник 5:19).

Хүн гэмшиж, уучлагдахын тулд Бурханаас гэмшлийн сүнс өгч байж л тэр гэмшлийг хүлээн авч, уучилж өгдөг юм. Бурханы өмнө гэмшин гэмийн ханыг нураахгүй юм бол Бурхан Египетээс гарсан нь 32:23-д, “Миний эсрэг гэм нүгэл үйлдсэн хүний нэрийг Би Өөрийн Номноос хасан арилгах болно” хэмээн айлдсантай адил байх ба Бурханы амийн номон дээр тэмдэглэгдсэн ч тэр нэр арилах боломжтой гэдгийг ямагт санахыг хүсье (Илчлэлт 3:5).

Энэ мэт үхэнд хүргэх гэм нүглийг үйлдвэл гэмшлийн энэрэл ивээлийг авах боломжгүй гэдгийг сайтар ухаарч явч үхэлд хүргэх гэм нүглийг хийхгүй байх хэрэгтэй юм.

Мөн үхэл хүргэхгүй гэм нүглийг ч гэсэн хаяхгүй байлгаад л байвал Ариун Сүнсний бялхалыг авах боломжгүй, харин ч сатаны уруу таталтанд унаад үхэлд хүргэх гэм үйлдэх боломжтой бөгөөд аврал хүртлээ ч гэсэн ичгүүрт аврал хүртэхээс өөр аргагүй билээ.

Тиймээс, бид гэм нүглийг цус урсгах мэт тэмцэн хаяж хорон муугийн хэлбэрийг ч хүртэл хаяад дахин ирэх Эзэнийг баяртайгаар угтан авахыг Эзэн Есүс Христийн нэрээр хүсэн ерөөе!

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
<http://www.manmin.org/english>
e-mail: manminministry@hotmail.com

Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин

Бурханы агуу хүчийг үзсэн эмч нарын гэрчиллэл

WCDN (Дэлхийн Христэч эмч нарын сүлжээ) 9 дэх удаагийн “Олон улсын Христэч Эмч нарын чуулга уулзалт” Тавдугаар сарын 25-наас 26-ны хооронд Кени улсад болж өнгөрлөө. Тус чуулга уулзалтанд 37 орны 400 гаруй эмч нар оролцон, Бурханы эрх мэдэлт хүчээр эдгээгдсэн гэрчлэл болон нотолгоо баримтын хамтаар илтгэл тавигдаж, “Итгэл ба Анагаах ухаан” сэдэвт семинар болж өнгөрлөө. Тэдгээрээс хоёр илтгэлийг дор дурдан оруулалаа.



Илтгэл тавьсан: Ян Чан Гюу Рентген туяа эмчилгээний Эмч

“Хагалгаа хийлгүйгээр хөхний хорт хавдар эдгэрсэн нь үнэхээр гайхалтай явдал юм.”

Би 1,болон 2, 6-р “Олон улсын Христэч Эмч нарын чуулга уулзалт” уудад тус тус оролцож байсан ба оролцох тус бүрт өөр өөр сэдвээр илтгэл тавьж байсан юм.Тухайлбал нурууны диск өвчин, үе мөчний, ясны шохойжилт болон бамбай булчирхайн хурц хэлбэрийн тухай тус тус танилцуулсан юм. Тэгэхдээ эдгээр илтгэлүүд нь нэг зүйлээр хоорондоо адил бөгөөд, эдгээр өвчтөнүүд нь бүгдээрээ эмнэлэг юм уу эмэнд найдалгүй Бурхандаа итгэх итгэлээр эрх мэдэлт хүчит залбирлаар эдгэрсэн тухай юм. Энэ удаагийн чуулга уулзалтан дээр тавьсан илтгэл ч гэсэн хорт хавдараас эдгэрсэн гэрчлэл ба ямар ч хагалгаа хийлгэлгүй эдгэрсэн юм.

Хөхний хорт хавдраас эдгэрсэн Хан Ин уг сүмд үйлчлэгч нь 2006 оны өвөл баруун хөхөнд нь хөндүүртэй булуу үүссэн юм. 2007 оны Дөрөвдүгээр сард хөхний зураг болон эхо ба эд эсийн шинжилгээнд ороод 2.17 см-ийн хэмжээтэй булуу бүхий хөхний хорт хавдартай хэмээн оношлогдсон юм. Гэвч Бүтээгч Бурханд итгэдэг учир итгэлээрээ эдгэрэхийг хүсэн эмнэлэгийн ямар ч үйлчилгээ аваагүй юм.

Цаг хугацаа өнгөрөх тусам түүний баруун хөх хөндүүрлэн өвдөж,улмаар баруун гар болон суга руу хүртэл өвдөж байсан боловч, долоо хоног бүрийн сургаалиар дамжуулан бардамнах, үзэн ядах, гомдоллох, бусдыг буруутгах Бурханд итгэхээс өмнө хиймэл шүтээн шүтэх, зэрэг нь ямар том гэм нүгэл болохыг ухаарч чин сэтгэлээсээ гэмшсэн билээ. Мөн библид бичигдсэнчлэн Бурханы хүсэж буй сайны зүрх сэтгэлийг бий болгохын тулд хичээнгүйлэн зүтгэж байсан юм. 2009 онд тэрээр зүүдээрээ дамжуулан “Эрх мэдэлт хүчний гэрэл орж ирж байна” гэсэн үгийг сонсоод илүү ихээр итгэлээрээ залбирч байв.


2011 оны Зургадугаар сарын 10-нд Манмин Төв Сүмд болсон “Онцгой Ивээлийн цуглаан” д оролцож, Доктор И Жей руг тэргүүн пасторын залбирал авсаны дараа өвчин хөндүүр нь арилж, хөхөнд нь хуралдан байсан булуу нь багасаж байлаа. Удалгүй 2011 оны Зургадугаар сарын 29-нд, тэрээр дахин шинжилгээ хийлгэхэд хариу нь хөхний хавдар нь төгс эдгэрсэн бөгөөд харин жижиг хоргүй эсийн бичил булуу үлдсэн байхыг л олж мэдэв.

Энэ удаагийн чуулга уулзалтан дээр энэ эмэгтэй хэрхэн эдгэрсэн тухай гэрчлэхийн тулд түүний шинжилгээний хариуг танилцуулж байгаа юм. Тиймээс тэр жижиг хоргүй эсийн бичил булууны Зхэсэгт нарийн шинжилгээ хийсэн ба хариу нь хорт хавдрын эс огт илрээгүй бөгөөд хэвийн эрүүл эмэгтэйд элбэг тохиолдох жижиг булуу(fibrosis) болох нь тогтоогдсон юм. Эндээс харахад аль хэдийн хөхний хорт хавдар ор мөргүй,төгс эдгээгдсэн болох нь батлагдсан юм.


Энэ удаагийн чуулга уулзалтын зохион байгуулах хорооны дарга Доктор Зиппора Өнгуми энэ илтгэл дууссаны дараа, “Ингэж рентген туяа эмчилгээний мэргэжлийн эмч хүн энэ өвчтөний эдгэрэхээс өмнө ба эдгэрсний дараах байдлыг баттай нотолгоогоо болон шинжилгээний хариутай хамт тавьсан илтгэл нь үнэхээр гайхалтай байлаа” хэмээн гайхаж, мөн ихэд сэтгэл хөдлөн өгүүлсэн юм. Мөн олон эмч нарын анхаарлыг татсан ба энэ нь хөхний хорт хавдар нь хагалгаа хийлгүй эдгэрч байсан материал ингэж бодитоор үзэж байсан удаагүй бөгөөд эрдэм шинжилгээний баримтуудаас ч гэсэн ийм ямар нэгэн эмчилгээгүйгээр эдгэрч байсан тохиолдолтой огт тулгарч байгаагүй учраас юм.



Хөхний хорт хавдраасаа эдгэрсэн Хан Ин уг сүмд үйлчлэгч



Хөхний зураг 2 см том булуу алга болсон байдал



Хэт ягаан туяаны шинжилгээний хариу_2.17см хэмжээтэй булуу алга болсон байдал



Илтгэлийг судлан тавьсан: Ким Жун сон Солонгос, Улсан их сургууль, Анагаах ухааны сургуулийн Хүүхдийн эмчилгээний тэнхимийн багш

“Бурханы хүч чадлаар хараа сайжирсан тухай илтгэл тавихад баяртай байна.”

Нүдний харааны бэрхшээл гэдэг нь анагаах ухааны хэллэгээр нүд юм харахгүй байх, мөн 0.3 –с доош үзүүлэлттэй зүйлсийг хардаг хүмүүсийг хэлдэг билээ. Энэ асуудлаас болж маш олон хүмүүс өдөр тутмын амьдралдаа болон санхүүгийн чадваргүйгээс болоод мөн сэтгэл санаагаараа зовж шаналдаг билээ.2010 оны ДЭМБ (Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага)-н судалгаагаар дэлхийн хэмжээнд 281 сая хүн дээрх нүдний харааны бэрхшээлтэй бөгөөд ойрын хараа, холын хараа, хялар буюу бусад төрлийн харааны саажилттай болох нь тогтоогдсон юм.

Би энэ удаагийн чуулга уулзалтан дээр статистикийн судалгааны дагуу 38 гаруй хүний нүдний хараатай холбоотой өвчтөний түүхүүдийг залбирал авахын өмнө ба дараах эдгэрсэн байдлыг хавсаргасан билээ. Эдгээрээс харахад Бурханы хүч чадлаар нүдний хараа илт сайжирсан ба сэргэсэн байгааг олж үзэх боломжтой юм.

Тэр дундаас иш татвал Хам Жун уг сүмд үйлчлэгч (32 настай эр) ойрын хараа муу байсан бөгөөд 16 жилийн турш нүдний шил зүүдэг байсан тэрээр “Онцгой Ивээлийн цуглаан” д оролцохын тулд өнгөрсөн амьдралаа эргэн санаж чин сэтгэлээсээ гэмшсэнээр 2011 оны Зургадугаар сарын 10-нд тэрээр Доктор И Жей руг тэргүүн пасторын залбирал авсан юм. Түүний дараахан өөрийнхөө нүдний хараагаа эмнэлэгт очиж шалгуулахад түүний баруун нүд нь 0.3-аас 05 ба зүүн нүд нь 0.9-оос 1.0 болтлоо сайжирсан байхыг олж мэдсэн юм.

Ким Буг хи сүмд үйлчлэгч (46 настай эм) ойрын хараа муутай байсан тул 15 жилийн турш нүдний шил зүүж байв. Тэрээр нүдний шил зүүдэг байсан жоохон хол зүйлийг сайн харж чадахгүй бүдэг бадаг хардаг байсан тул түүнд маш хүнд байдаг байв. Гэвч тэрээр 2011 оны Зургадугаар сарын 17-нд Доктор И Жей руг тэргүүн пасторын залбирал авсан юм. Залбирал авч байхдаа түүний нүдэнд халуу дүүгэх шиг мэдрэмж төрсөн ба залбиралын дараа эргэн тойрны зүйлийг тод хардаг болсон ба нүдний хараагаа шалгуулахад түүний хараа нь 0.4/0.2-оос 0.8/0.8 болтлоо сайжирсан байв.

Орчин үеийн анагаах ухаан болон эмчилгээний олон шинэ технологи төхөөрөмжүүд бий болсон ч гэсэн мэс засал болон эмээр эмчлэхэд ч амар биш байдаг энэ мэт харааны бэрхшээлийг Бурханы хүч чадлаар дамжуулан сэргэж, хэвийн болсон нь үнэхээр гайхамшигтай билээ. Энэ мэт гэрчлэлүүдийг христчин эмчийн хүний хувьд цуглуулан илтгэл тавьж олон хүмүүст танилцуулна гэдэг нь үнэхээр аз жаргалтай хэрэг билээ. Бүхий л талархал ба алдарыг Бурхандаа өргөн барьж байна.



Хам Жун уг сүмд үйлчлэгч



Ким Буг хи сүмд үйлчлэгч

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

залбирал цагийн хуваарь

Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30	Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30			
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00	Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30			
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00	Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00			
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00			

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Кени улсад болсон WCDN (ДХЭС) 9-р чуулга уулзалтанд 37 орны эмч нар нэгэн дор хуран чууллаа



Африкийн Кени улсад зохион байгуулагдсан ДХЭС-ний Олон улсын 9-р конференц уулзалтанд нийт 37 орны 400-аад эмч нар оролцов. Амьд Бурханы агуу гайхамшигт хүчит үйлсүүдийн танилцуулга тавигдсан ба анагаах ухааны онолын хатуу ойлголтуудыг буталж өгч тэдэнд Бурханд итгэх итгэлийн үрийг суулгах чухал арга хэмжээ болж өнгөрлөө.

2012 оны Тавдугаар сарын 25-26-нд WCDN(Дэлхийн Христийн Эмч нарын сүлжээ) зохион байгуулагдсан Олон Улсын Христийн Эмч Нарын 9-р чуулга уулзалт Кени улсын Найроби хотын Сафари Парк зочид буудалд болж өнгөрөв.

Тус Чуулга уулзалт нь “Сүнслэг байдал болон Анагаах ухаан” хэмээх сэдвийн дор нийт 37 орны 400-аад эмч нар оролцов. Тавдугаар сарын 25-нд, ДХЭС-ний үндэслэгч Доктор И Жей руг пастор хурал цугларагсадад хандан “Бурханы эдгээх хүч нөлөөгөөр дамжуулан Эзний хайрыг өргөнөөр тараадаг эмч нар болохыг хүсэж байна” гэсэн мэндчилгээ дамжуулсан юм.

Үүний дараа ДХЭС-ийн дарга Доктор Чэ Юун сог доктор нь нээлтийн үг хэлж ДХЭС-ний үндсэн гол зорилго болон ирээдүйн алсын харааг Христийн эмч нарт танилцууллаа. Үүний дараа, энэ удаагийн чуулга уулзалтыг зохион байгуулах комиссын дарга Доктор Зиппора Онгуми нь үг хэлэхдээ Христчин эмч нарын гол зорилго болон тэдний үүргийн талаар өөрийн саналаа хуваалцсан юм.

Түүнчлэн манай төв сүмийн Жон Гү ёон пасторын сургалт семинараар дамжуулан “Бурханд хайртай байх баталгаа нь Бурханы бүх хууль тушаалуудыг сахих явдал юм. Энэ мэт ариухан амьдралаар амьдрахад л Бурхан ерөөлөө хайрлан энэ газарт ч төдийгүй ирээдүйд тэнгэрийн оронд ч орох болно” хэмээн айлдсан юм.

Энэ удаагийн чуулга уулзалтан дээр найман төрлийн эдгэрэлийн гэрчлэл болон тус бүр өвчний түүхтэй хавсаргагдсан ба дөрвөн гэрчлэл нь Доктор И Жей руг пасторын залбирал ба гар алчуурын залбирал (Үйлс19:11-12) аван эдгэрсэн тухай илтгэл тавигдсан билээ.

Улсан Их Сургуулийн Хүүхдийн

эмчилгээний тэнхимийн багш Доктор Ким Жүн-сун эмчийн тавьсан илтгэл нь Доктор И Жей руг пасторын залбирлаар нүдний хараа сайжирсан тухай байсан бол Рентген туяа эмчилгээний эмч Ян Чан Гю эмч хөхний хорт хавдраас эдгэрсэн тухай тус тус танилцуулав.

Мөн Едит Опала хэмээх Кени эмч Кения Майкл хэмээх нэгэн цагдаагын офицер бэлхүүснээсээ доош мэдээгүй болсон байсан ба Африк дахь Есүс Христийн Ариун сайн мэдээний нэгдсэн сүмийн пастор Доктор Чон Мён хо пасторын залбиралыг аваад тэргэнцэрээсээ босон алхдаг болсон тухай дурдан танилцуулав. Доктор Брайн С. Уео гуай (Россарин 16 эм) нэгэн Тайланд охин арьсны лупус хэмээх өвчнөөр өвдөж байхдаа GCN телевизээр дамжуулан Доктор И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлаар дамжуулан төгс эдгэрсэн тухай гэрчлэн илтгэл тавьсан юм.

Ямар нэгэн эмчилгээгүйгээр зөвхөн залбирлаар дамжуулан эдгэрсэн тухай гэрчлэх тоолонд эмч нарын анагаах ухааны онолын хатуу ойлголтууд хагарч, Бурханы амьд оршин буй ба төгс хүч чадлыг гайхан тагтаагаж байлаа.

Үүнээс гадна Бринда Венктраман хэмээх нэгэн эмэгтэй Энэтхэг эмч нурууны диск өвчнөөр өвдөөд 18 жил болж байсан ба хагалгаа хийлгэлгүйгээр зөвхөн залбирлаар эдгэрсэн тухай гэрчилж, энэ удаагийн чуулга уулзалтыг зохион байгуулах комиссын дарга Доктор Зиппора Онгуми нь үхэрт мөргүүлэн хөлийн гуя хэсэгт нэвт хатгуулаад өвчин эдгээх залбирлаар дамжуулан Африк эмэгтэйн тухай танилцуулав. Доминикан улсаас ирсэн Доктор Елио А. Коррадин хэвлийн хорт хавдраас эдгэрсэн тухай танилцуулга хийв. АНУ-аас ирсэн Доктор

Армандо Пинеда-Велез хэмээх эмч шулуун гэдэсний өвчилөлтөөс эдгэрсэн тухай танилцуулга хийв.

Танилцуулгууд хийгдсэний дараа асуулт хариулт явагдав. Танилцуулагдсан түүхүүдийн зарим нь бодит жишээ болгон хүмүүс өөрсдөө ирцгээн гэрчилж байсан нь оролцогч олны анхаарлыг татаж байв. Үүнээс гадна Анагаах ухаан ба сүнслэг байдлыг хамруулсан тусгай лекцүүд тавигдаж байв.

Төгсгөлийн үйл ажиллагааны үеэр Найроби Манмин Ариун Сүмийн хариуцагч пастор Доктор Чон Мён хо пастор айлдахдаа “Эмч нарт маш чухал хэрэгтэй зүйл нь Бурханы Үг билээ. Бурханы үг байгаа учраас өвчтөнүүдэд Бурханы сургаалыг зааж, тэдний төлөө залбирал хийж өгөх боломжтой” хэмээн айлдсан юм.

Васили Вотович пастор АНУ-д ТВ компани ажиллуулдаг нэгэн бөгөөд, “Би ДХЭС чуулга уулзалтын үйл ажиллагаан жил болгон цацан нэвтрүүлж байдаг ба олон мянган үзэгчид талархан хүлээн авч байдаг билээ. Эмч нар Бурханы сургаалыг тунхаглан өвчтөнүүдэдээ тараан гэрчилэлээ хуваалцах нь олон хүнийг авралд хүргэх боломжтой билээ” хэмээн хэлэв.

Энэ удаагийн ДХЭС-ийн энэхүү чуулга уулзалтыг Өмнөд Солонгосын эмч нарын баг удирдах байгуулгатай хамт зохион байгуулсан билээ. ДХЭС нь дэлхийн олон орны эмч нарыг хооронд нь нэгтгэн нөхөрсөг холбоо тогтоон жил бүр конференц зохион байгуулан Христийн эмч нарын танилцуулгуудыг үзэгч олондоо танилцуулсаар байдаг билээ. ДХЭС нь дараа жил Мексик улсад конференц зохион байгуулахаар төлөвлөж байгаа юм.



- 1) ДХЭС-ийн үүсгэгч, Доктор Жаерок Лее гуайн видео сургаал
- 2) Хүрэлцэн ирэгсэд аз жаргал баяр баясгалангаар дүүрсэн байгаа нь
- 3) Конференцийн Зохицуулах Комиссын дарга Доктор Зиппора Онгуми
- 4) ДХЭС-ийн Ерөнхийлөгч Доктор Гилберт Чае
- 5) Болор Дуулаачидын урлагын тоглолт

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
 www.manmintv.org